



**ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 12/01

Эрдэнэт

**Хуралдааны дэг батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 46 дугаар зүйлийн 46.9 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XII хуралдааны дэгийг хавсралтаар баталсугай.

2. Хуралдааны дэгийг мөрдөж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Хуралдаанд оролцогчдод үүрэг болгосугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн Ээлжит XII хуралдааны 12/01 дүгээр тогтоолын хавсралт

## АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ XII ХУРАЛДААНЫ ДЭГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн Ээлжит XII хуралдаан 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 09:00 цагт цахимаар хэлбэрээр zoom программд холбогдсоноор эхэлнэ.


Хурлын хуралдаанд Хурлын дарга, аймгийн Засаг даргын орлогч, аймгийн ЗДТГ-ын дарга, Хэлтсийн дарга нар, Ажлын албаны мэргэжилтнүүд, тухайн асуудлыг танилцуулах илтгэгч нар нутгийн удирдлагын ордны Ажлын кабинетаас оролцоно.

Бусад оролцогчид zoom программ ашиглах шаардлага хангасан техник хэрэгслийн бэлэн байдлыг өөрөө хангаж, байгаа байршлаас тус тус оролцоно.

1. "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах" үндэсний хөдөлгөөний хүрээнд Орхон аймагт 2022-2027 онд хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай  
15 мин
2. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлах тухай  
15 мин
3. Аймгийн 2023 онд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээг батлах тухай  
10 мин
4. Аймгийн 2023 онд цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тоог тогтоох тухай  
10 мин
5. Олон нийтийн цагдаагийн тоог тогтоох тухай  
10 мин
6. Орон нутгийн өмчийн 2022 оны улсын үзлэг тооллогын дүнг батлах тухай  
10 мин
7. Аймгийн хэмжээнд 2022 онд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөөний биелэлт, 2023 онд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөө батлах тухай  
15 мин
8. Журам шинэчлэн батлах тухай  
10 мин
9. Орон тооны бус зөвлөл байгуулах тухай  
10 мин
10. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг шинэчлэн батлах тухай  
10 мин
11. Аймгийн хэмжээнд төр, сүм, хийдийн харилцааг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай  
5 мин
12. Хугацаа сунгах тухай  
5 мин
13. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай  
10 мин
14. Зөвшөөрөл олгох тухай  
15 мин
15. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит XII хуралдаан цахимаар зохион байгуулагдаж байгаатай холбоотойгоор хэлэлцэж байгаа асуудлаар гарах шийдвэрийн төслийг эцэслэн боловсруулах

Редакцын комисс, санал хураалтын үйл ажиллагааг зохион байгуулах, дүнг гаргах Тооллогын комиссын үүргийг Хурлын ажлын албанаас эрхлэн зохион байгуулна.

16. Хуралд оролцох Төлөөлөгчдийн ирцийг Хурлын ажлын албанаас бүртгэнэ. Төлөөлөгчид zoom программд холбогдсоноор хуралдаанд оролцсонд тооцох ба дэлгэц дээр бүртгэнэ.
17. Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Хурлын төлөөлөгч зориудаар хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно. Хуралдаанд зориудаар оролцоогүй буюу орхиж гарсан тохиолдолд хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.
18. Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, санал хэлэх хугацаа хүн тус бүрд эхний удаа 3 хүртэл минут, хоёр дахь удаа 2 хүртэл минут байна.
19. Тухайн асуудлаар асуулт асуух, санал хэлэх Төлөөлөгчдийн нэрсийг хуралдааны удирдлагын зүгээс урьдчилан авч дараалалд оруулна. Цахим программыг удирдаж байгаа админы зүгээс асуулт болон санал гэсэн үгийг zoom программын chat хэсэгт бичсэний дараагаас эхлэн 1 минутын дотор Төлөөлөгч өөрийн нэрээ урьдчилан бичнэ.
20. Тухайн хэлэлцэж байгаа асуудлаар эцсийн шийдвэр гаргах, асуулт, хариулт, санал, шүүмжлэлийг таслахдаа санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.
21. Хэлэлцэж байгаа асуудлаар цөөнх болсон Төлөөлөгчдийн үндэслэл, саналыг сонсож, дахин нэг удаа санал хураалт явуулж болно.
22. Асуулт тавих, үг хэлэх, санал шүүмжлэл гаргах зөвшөөрлийг хуралдааны удирдлага олгож тогтоосон хугацааг баримтална.
23. Хэлэлцэж байгаа асуудлын талаар Хорооны санал, дүгнэлтийг тухайн хорооны дарга танилцуулна.
24. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Намын бүлэг завсарлага авч болох бөгөөд завсарлагын хугацаа 1 цаг хүртэл байна. Завсарлага авснаас хойш бүлгээс тухайн асуудалд нэгдсэн байр суурь илэрхийлж хуралдаанд оролцоно.
25. Намын бүлэгт олгосон завсарлагын хугацаа сунгах шаардлага гарвал хуралдаанаар шийдвэрлэх бөгөөд тогтоосон хугацааг чанд баримтална.
26. Хуралдааныг 2 цаг тутамд 15 минутын завсарлагаатай явуулна.
27. Өдрийн их завсарлага 13.00-14.00 цагийн хооронд байна.
28. Хуралдаан тухайн ажлын өдөр багтахгүй бол үргэлжлүүлэх аль эсвэл дараачийн өдөр шилжүүлэх асуудлыг санал хураалт явуулж олонхын саналаар шийдвэрлэнэ.
29. Хуралдааны танхимд иргэдтэй харилцах 7035-0494 дугаарын утас ажиллана. Иргэдтэй харилцах утаснаас ирүүлсэн хувь хүний нэр төртэй холбоотойгоос бусад саналыг багцлан хуралдаанд танилцуулж, шаардлагатай бол холбогдох албан тушаалтнаар хариу тайлбар өгүүлнэ.
30. Хуралдааныг “Номин”, “ETV” телевизээр шууд дамжуулах бөгөөд тус телевизүүд бусад орон нутгийн телевиз, сайт зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, иргэдэд мэдээлэл дамжуулах боломжийг хангана.



31.Хуралдааны тэмдэглэлийг Хурлын зохион байгуулалт, хууль эрх зүй хариуцсан ахлах мэргэжилтэн хөтөлнө.

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ЭЭЛЖИТ XII ХУРАЛДААН

